

БНСУ-д удаан хугацаагаар оршин сууж буй хүүхдийн сурах эрхийг хангах зорилгоор виз олгох журам(2025.4.1 ~ 2028.3.31 хүртэл)

1 Бүртгүүлэх хугацаа болон хамрагдах нөхцөл

□ Бүртгүүлэх хугацаа

○ 2025. 04. 01. ~ 2028. 03. 31. хүртэл

□ Виз олгох журамд хамрагдах хүүхэд

- ① ▲БНСУ-д төрсөн эсвэл 6-аас доош насандаа тус улсын хилээр орж ирсэн ▲БНСУ-д 6-аас дээш жил оршин суусан ▲Өргөдөл гаргах үед БНСУ-д бага, дунд, ахлах сургуульд суралцаж байх эсвэл төгссөн
- ② ▲БНСУ-д хилээр 6-аас дээш насандаа орж ирсэн ▲БНСУ-д 7-оос дээш жил оршин суусан ▲Өргөдөл гаргах үед БНСУ-д бага, дунд, ахлах сургуульд суралцаж байх эсвэл төгссөн

2 Авах арга хэмжээ

□ Хүүхдэд авах арга хэмжээ

- ① Хүсэлт гаргах үед бага, дунд болон ахлах сургуульд суралцаж байгаа тохиолдолд
 - Ахлах сургууль төгсөх хүртэл хугацаанд суралцах (D-4) ангилалын оршин суух эрх олгоно.
- ② Хүсэлт гаргах үед ахлах сургуулиа төгссөн тохиолдолд
 - Суралцах, ажиллах нөхцлийг хангаж байгаа тохиолдолд тухайн нөхцөлд нийцсэн оршин суух эрхийг өөрчлөн олгоно. ▲
 - Суралцах болон ажиллах нөхцлийг хангаагүй тохиолдолд 1 жилийн түр хугацааны оршин суух (G-1) ангилалын оршин суух эрх олгон өөрчлөх.
- ③ Сургуулиас хасагдах эсвэл дүрэм журам зөрчих зэргээр нөхцлөө мөрдөж чадаагүй тохиолдолд
 - Цагаачлалын тухай хуульд заасны дагуу визийг цуцлах эсвэл сунгахаас татгалзах.

□ Хүүхдийн насанд хүрээгүй ах, эгч дүү нарт авах арга хэмжээ

- Шаардлага хангасан хүүхдэд виз олгохдоо тухайн хүүхдийн насанд хүрээгүй ах, эгч дүү нарт бусад (G-1) виз хамтад нь олгох гэр бүлийн тогтвортой байдлыг хангах.

□ Хүүхдийн эцэг эхэд авах арга хэмжээ

○ Авах арга хэмжээ

- Үндсэн журмын дагуу БНСУ-ын нутаг дэвсгэрээс гарах ёстой боловч, насанд хүрээгүй хүүхдээ асран хамгаалах шаардлагатай тул хүүхдийг насанд хүрэх хүртэл түр хугацааг аар тус улсад оршин суух зөвшөөрөл олгох.
- Харин тус улсад хүүхдийг бодитоор асран хамгаалж, өсгөөгүй эцэг эх нь уг журмын хамрах хүрээнээс хасагдана.

① Эцэг эхийн хууль зөрчсөн үйлдэлд торгууль ногдуулах

- Хүүхдийн оршин суух зөвшөөрөл хүссэн эцэг эхийг хууль бусаар оршин сууж байгаа үеийн зөрчилд торгууль ногдуулах *
- * Торгууль төлөх төлбөрийн чадваргүй эсвэл тусгай шалтгаантай бол торгуулийг дахин бууруулах арга хэмжээ авна.
- Эцэг эх нь торгуулиа төлсөн тохиолдолд хүүхдийг ахлах сургуулиа төгсөх болон насанд хүрэх хүртэл хугацаанд (G-1) оршин суух виз олгох бөгөөд, хүүхдийг асран хамгаалах зорилгоор хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгоно.

② Түр оршин суух зөвшөөрөл олгох болон хилээр гаргах арга хэмжээ

- Хүүхдээ ахлах сургуулиа төгсөх буюу насанд хүрэх үед эцэг эх өөрийн санаачилгаар эх орондоо бцах ёстой бөгөөд хэрэв буцалгүй хууль бус оршин суугч болсон тохиолдолд албадан гаргаж, дахин БНСУ-д нэвтрэхийг хязгаарлана.

③ Эцэг эхчүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх

- Эцэг эхийн хүүхдийн боловсрол, хүмүүжилд тавих хариуцлагыг нэмэгдүүлэхийн тулд нийгмийн нэгдсэн хөтөлбөрт хамрагдах зэрэг нөхцөлийг тавьна.
- * Нийгмийн нэгдсэн хөтөлбөр(Хууль зүйн яам), Хүүхдийн боловсрол хүмүүжлийн сургалт(холбогдох яам)

③ Хүсэлт гаргахтай холбоотой бичиг баримтын мэдээлэл авах

- Маягт болон бүрдүүлэх бичиг баримтын мэдээлэл : БНСУ-ын Хууль зүйн яамны ха

рьяа Цагаачлалын албаны бодлогын хэлтэс(www.immigration.go.kr) болон (www.hikorea.go.kr) сайтуудаас мэдээлэл авч болно.

○ Хүсэлт гаргахтай холбоотой мэдээлэл авах: Хүсэлтээ оршин суугаа газрын харьяа Цагаачлалын албанд гаргана. Хууль зүйн яамны харьяа Гадаадын иргэдийн нэгдсэн зөвлөгөө өгөх төв(Утасны дугаар 1345, орчуулгийн үйлчилгээ үзүүлнэ.)

※ Ажлын цагийн хуваарь 09:00~22:00(Бямба, ням, бүх нийтийн амралтын өдрүүдэд амрана.), 18 цагаас хойш солонгос, англи, хятад хэлээр зөвлөгөө авч болно.